



ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, 11 дүгээр хороолол,
Энхтайваны өргөн чөлөө 10а, Багшийн хөгжлийн ордон
Утас/Факс: (976) 7011-3033
<http://www.edub.edu.mn>

2018.02.28 № 02/204
танай _____ -ны № _____ -т

Чиглэл хүргүүлэх тухай

БСШУС-ын сайдын “Музейн нээлттэй өдрүүд” зохион байгуулах тухай 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/071 дүгээр тушаал гарсантай холбогдуулан эх түүх, монгол ахуй, соёл, өв уламжлалыг хадгалах, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад 2018 оны 03 дугаар сарын 01-нээс 07-ны өдрүүдэд музей үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна уу.

Иймд хавсралтаар хүргүүлсэн хуваарийн дагуу дүүргийнхээ ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үнэ төлбөргүй музей үзүүлэх ажлыг зохион байгуулж, тайланг хүснэгтийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 09-ний дотор www.olonmekh@edub.edu.mn хаягаар ирүүлнэ үү.

Музейн үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа сурагчдын аюулгүй байдалд онцгой анхаарч, удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангаж ажиллахыг чиглэл болгож байна.

Хавсралт 3 хуудас

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДАД
МУЗЕЙ ҮЗҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	Сар өдөр	III/01	III/02	III/03	III/04	III/05	III/06	III/07
1	Төрийн түүхийн музей	БГД	БЗД	НД, БНД, БХД	СБД	ХУД	ЧД	СХД
2	Чойжин ламын сүм музей	БГД	БЗД	НД, БНД, БХД	СБД	ХУД	ЧД	СХД
3	Богд хааны ордон музей	СХД	БГД	БЗД	НД, БНД, БХД	СБД	ХУД	ЧД
4	Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей	ЧД	СХД	БГД	БЗД	СХД	СБД	ХУД
5	Монголын үндэсний музей	ХУД	ЧД	НД, БНД, БХД	БГД	БЗД	СХД	СБД
6	Улаанбаатар хотын түүхийн музей	СБД	ХУД	СХД	НД, БНД, БХД	БГД	БЗД	ЧД
7	Монгол цэргийн музей	СБД	ХУД	СХД	НД, БНД, БХД	БГД	БЗД	ЧД
8	Үлэг гүрвэлийн музей	СХД	СБД	ХУД	НД, БНД, БХД	ЧД	БГД	БЗД
9	Театрын музей	БЗД	ЧД	СБД	ХУД	СХД	НД, БНД, БХД	БГД
10	Монголын уран зургийн галерей	БЗД	ЧД	СБД	ХУД	СХД	НД, БНД, БХД	БГД

“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД” ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

№	Сургууль /сургуулийн тоо/	Зохион байгуулсан үйл ажиллагаа	Оролцогчдын тоо		
			Багш	Сурагч	Нийт
1		Төрийн түүхийн музей			
2		Чойжин ламын сүм музей			
3		Богд хааны ордон музей			
4		Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей			
5		Монголын үндэсний музей			
6		Улаанбаатар хотын түүхийн музей			
7		Монгол цэргийн музей			
8		Үлэг гүрвэлийн музей			
9		Театрын музей			
10		Монголын уран зургийн галерей			
Нийт					



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дүгээр 1/041

Улсынбаатар хот

"Музейн нээлттэй өдрүүд"
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 3.2.44-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын биет өвд тулгуурлан хүүхэд залуучуудад монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, нийгмийн хөгжилд музейн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн 3 дугаар сарын эхний 7 хоногт "Музейн нээлттэй өдрүүд" арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлсүгэй.

2. Улс, орон нутгийн музейн захирал, эрхлэгч нарт үүрэг болгох нь:


2.1. "Музейн нээлттэй өдрүүд"-ээр Монголын түүх, соёл, зан заншил, үндэсний бахархалт үнэт зүйлсийг сурталчлан таниулах чиглэлээр тусгай үзэсгэлэн гаргах, төрөл бүрийн боловсролын ажил зохион байгуулсугай.

2.2. Иргэн, төр, хувийн хэвшлийн музей, соёлын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хамтран ажилласугай.

2.3. "Музейн нээлттэй өдрүүд"-ээр музейг иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээ авсугай.

3. "Музейн нээлттэй өдрүүд"-ийг зохион байгуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг тухайн оны 4 дүгээр сарын 01-ний дотор танилцуулж байхыг Соёл, урлагийн бодлогын газар /Б.Сэргэлэн/-т даалгасугай.

САЙД



ЦОГЗОЛМАА

0000704